

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

___оны ___сарын ___өдөр

Дугаар___

Дархан

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх,
түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах болон
эдгээр үйл ажиллагааны төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ын 9 дэх хэсгийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, түгжрэл саатлыг бууруулах зорилгоор Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд хориглосон газар, Дархан сумын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл түр зогсохыг хориглох гудамж, зам, хамрах хүрээнд зогссон тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх цагийг 07:00-21:00 цагийн хооронд тогтоосугай.

2.Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах журмыг нэгдүгээр, тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагааны төлбөрийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх үйл ажиллагааг эрхлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулахад тавигдах шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Азжаргал/-д зөвшөөрсүгэй.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д даалгасугай.

5.Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа (Б.Нацагдорж)-д үүрэг болгосугай.

6.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа ажиллуулах, гудамж зам, хамрах хүрээ, үйлчлэх цаг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 10/05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

7.Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд холбогдох журмын дагуу бүртгүүлэхийг Эрх зүй, дотоод хяналтын хэлтэс (Э.Золзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

С.НАСАНБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын оны .. дугаар сарын ..-ны өдрийн ээлжит бус .. дугаар хуралдааны .. тогтоолын нэгдүгээр хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ, ТҮР СААТУУЛАХ ХАШАА /БАЙР/ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох, замын хөдөлгөөнд оролцогчдын хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг бууруулах, тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг дараах тохиолдолд баримтална:

1.2.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан эрхийн хүрээнд цагдаагийн байгууллага буюу алба хаагч тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхэд;

1.2.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д заасан үүргийн дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулахад тавигдах шаардлагыг ханган ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан аж, ахуйн нэгж, байгууллага энэхүү журмыг мөрдөж ажиллана.

1.3. Тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг гэрээгээр хариуцсан байгууллага энэхүү журамд заасныг баримтлаагүй бол гэрээг цуцлах үндэслэл болно.

1.4. Цагдаагийн алба хаагчийн шийдвэргүйгээр тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэхийг хориглоно.

Хоёр. Тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх үндэслэл

2.1. Цагдаагийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.4 дэх хэсэг, 33, 34 дүгээр зүйл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан үндэслэлээс гадна Дархан сумын нутаг дэвсгэрт тээврийн

хэрэгсэл түр зогсохыг хориглох гудамж, замд тээврийн хэрэгслийг байршуулсан бол зөөж шилжүүлж болно.

2.2. Дархан сумын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл түр зогсохыг хориглох гудамж, зам, хамрах хүрээ:

№	Гудамж, замын нэр	Хамрах хүрээ
1.	“DBS” телевизийн зүүн урд талд байрлах 4 замын уулзвараас ОХУ-ын Ерөнхий консулын газрын зүүн урд байрлах 4 замын уулзвар хүртэлх зам	Зорчих хэсгийн 2 талын урсгал
2.	ДСЦТС ХК-ийн нэрэмжит “Жаргалантын гудамж”-ны АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургуулийн хойно байрлах 4 замын уулзвараас “Ариг банк”-ны урд байрлах зогсоол хүртэл	Зорчих хэсгийн 2 талын урсгал
3.	“Ардын өргөн чөлөө” гудамжны Дархан-Уул аймаг дахь Давж заалдах шатны шүүхийн зүүн урд байрлах 4 замын уулзвараас “Буян зах”-ын баруун талын 4 замын уулзвар хүртэл	Зорчих хэсгийн 2 талын урсгал
4.	“Монгол банк”-ны урд 4-н замын уулзвараас Консулын газрын зүүн урд байрлах 4-н замын уулзвар хүртэлх зам (“Бурхантын гудамж”	Зорчих хэсгийн 2 талын урсгал
5.	“Монгол банк”-ны урд 4-н замын уулзвараас Номин худалдааны төвийн уулзвар хүртэлх зам.	Зорчих хэсгийн 2 талын урсгал

2.3. Эзэмшигч, өмчлөгч нь тогтоогдохгүй байгаа тээврийн хэрэгслийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор зөөж шилжүүлж болно.

2.4. Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 35, 37 дахь хэсэгт заасан зөрчилтэй тээврийн хэрэгслийг 10 км-ээс хол зайд зөөж шилжүүлэхгүй.

Гурав.Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх үйл ажиллагаа, түүнд тавигдах ерөнхий шаардлага

3.1. Тээврийн хэрэгслийн түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах байгууллага нь өөрийн эзэмшлийн зориулалтын чирэгч, ачигч тээврийн хэрэгсэлтэй байна. Зөөж шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор жолоочоос гадна техникийн ажилтан ажиллуулна.

3.2. Цагдаагийн байгууллага нь өөрийн харьяанд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх тусгай зориулалтын чирэгч, ачигч тээврийн хэрэгсэл, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулж болох ба энэ тохиолдолд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тогтоосон төлбөрийн хэмжээг мөрдөнө.

3.3. Цагдаагийн байгууллага нь тээврийн хэрэгслийг түр саатуулсан, зөөж шилжүүлсэн тухай мэдээллийг лавлах утсаар авах боломжоор хангах, энэ тухай иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулах бөгөөд тээврийн хэрэгслийг саатуулах үед эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн гар утасны дугаарт мессежээр мэдэгдэж болно.

3.4. Аймгийн Цагдаагийн газар нь тээврийн хэрэгсэл түр саатуулах, зөөж шилжүүлэх үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж ажиллана.

3.5. Цагдаагийн алба хаагч нь Цагдаагийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.4 дэх хэсэг, 33, 34 дүгээр зүйл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх шийдвэрийг бичгээр буюу цахимаар гаргана.

3.6. Энэ журмын 3.5-д заасан “бичгээр шийдвэр гаргах” гэдэгт тухайн зөрчил гарсан газарт байгаа албан хаагч зөөж шилжүүлэх шийдвэр бичиж тээврийн хэрэгсэлд ил харагдахуйцаар байрлуулах эсхүл ачигч /чирэгч/ автомашины жолоочид гардуулж өгөхийг ойлгоно.

3.7. Энэ журмын 3.5-д заасан “цахимаар шийдвэр гаргах” гэдэгт тухайн тээврийн хэрэгслийн байгаа газарт албан хаагч байхгүй тохиолдолд тээврийн хэрэгслийн байрлал, орчныг бүрэн хамруулсан зураг-дүрс бичлэгийг цахим төхөөрөмжөөр хүлээн авч, шийдвэрлэхийг ойлгоно.

3.8. Цагдаагийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх хэсэг, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 35, 37 дахь хэсэгт заасан үндэслэлээр тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэхдээ дараах үйл ажиллагааг явуулна:

3.8.1. тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэхийн өмнө болон шилжүүлэхээр бэлтгэж байх /ивүүр, татлага, бэхэлгээ хийх/ явцад тухайн тээврийн хэрэгслийн жолооч /эзэмшигч, өмчлөгч/ ирвэл шийтгэл оногдуулж, тээврийн хэрэгслийг хүлээлгэж өгөх;

3.8.2. энэ журмын 3.7-д заасан шийдвэрийн дагуу зөөж шилжүүлсэн тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийн хаягаар бэлэн бус хэлбэрээр шийтгэлийн хуудас хүргүүлэх;

3.8.3. албан хаагч тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх шийдвэрийг бичгээр гаргасан тохиолдолд техникийн ажилтан нь тухайн тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлмэгц тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар болон зөөж шилжүүлсэн шалтгаан, шийдвэрийг гаргасан албан тушаалтны нэр, хаана хүргэх талаарх мэдээллийг санд нэн даруй бүртгүүлэх.

3.9. Тээврийн хэрэгслийг түр саатуулахдаа зориулалтын чирэгч, ачигч тээврийн хэрэгсэл ашиглан зөөж шилжүүлнэ.

3.10. Зориулалтын чирэгч, ачигч тээврийн хэрэгсэл байхгүй үед болон овор ихтэй, хүнд даацын тээврийн хэрэгслийг түр саатуулах, эсхүл зөрчил гаргагч хүсэлт гаргаж, албан хаагч өөрөө боломжтой гэж үзсэн тохиолдолд тухайн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэх бүхий цагдаагийн алба хаагч жолоодож түр саатуулах хашаа /байр/-нд хүргэж болно.

3.11. Энэ журмын 3.7-д заасан зураг-дүрс бичлэгийг аймгийн цагдаагийн ерөнхий жижүүр, цагдаагийн эрх бүхий ажилтан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

3.11.1. тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах;

3.11.2. тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэхгүйгээр бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах;

3.11.3. энэ журмын 3.11.1, 3.11.2-д заасан аль нэг шийдвэрийг гаргахаас татгалзах.

3.12. Тусгай зориулалтын чирэгч, ачигч тээврийн хэрэгслийн жолооч нь СЕ эсхүл С1Е ангилалтай тээврийн хэрэгслийг 3-аас доошгүй жил жолоодсон, дадлага, туршлагатай, мэргэшсэн жолооч байх бөгөөд цагдаагийн ажилтнаас тээврийн хэрэгсэл түр саатуулах, зөөж шилжүүлэх талаар бичгээр буюу цахим хэлбэрээр өгсөн шийдвэрийн дагуу техникийн ажилтны тусламжтайгаар дараах ажиллагааг хийнэ:

3.12.1. зөөж шилжүүлэх ажиллагааг эхлэхийн өмнө анхааруулах зорилгоор 3-аас доошгүй удаа чанга яригчаар зарлан мэдэгдэх;

3.12.2. зөөж шилжүүлэх явцад тээврийн хэрэгсэл савж, гулсаж унахаас сэргийлж ивүүр, татлага, бэхэлгээ хэрэглэх;

3.12.3. зогсоолын тоормосыг дарсан, эсхүл хөдөлгүүрийн ачааллыг хүч дамжуулах ангиас салгагдаагүй тээврийн хэрэгслийг өргөж ачих болон нэмэлт дугуй хэрэглэх, харин зогсоолын тоормос дараагүй, хөдөлгүүрийн ачаалал хүч дамжуулах ангиас салгагдсан тээврийн хэрэгслийг хагас цоройлгон ачих байдлаар зөөж шилжүүлэх.

3.13. Ачигч автомашины жолооч, техникийн ажилтан нь тухайн тээврийн хэрэгслийн бүхээгт хүн, амьтан байгаа тохиолдолд зөөж шилжүүлэхгүй.

Дөрөв.Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа /байр/-нд тавигдах шаардлага, харуулын гүйцэтгэх үйл ажиллагаа

4.1. Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ нь даатгалтай, харуул хамгаалалтын ажилтантай, ил болон битүү зогсоолын хүрэлцэхүйц талбайтай, хашаа нь тортой, галын аюулгүй байдлын болон тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн

байдлыг хянах боломж бүхий камерын хяналтын системтэй, харанхуй үед үзэгдэх боломжийг хангасан гэрэлтүүлэгтэй, харуулын ажиллах нөхцөлийг хангасан ажлын байртай, холбоо, мэдээллийн хэрэгслээр тоноглогдсон байна.

4.2. Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-ны тус бүрийн зогсоолын /ил болон битүү зогсоолын/ нийт талбайн хэмжээ 1000м²-аас багагүй, зориулалтын чирэгч, ачигч автомашин /энэ журмын 3.12.3-т заасан шаардлагыг хангасан/-ы тоо 3-аас доошгүй байна.

4.3. Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-нд байлгах үеийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг аймгийн Цагдаагийн газар, хэрэв зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг гэрээгээр хариуцуулсан бол тухай байгууллага хариуцаж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтныг томилон ажиллуулна.

4.4. Тээврийн хэрэгслийг түр саатуулах байрны харуул нь дараах журмыг мөрдөж ажиллана:

4.4.1. зөвхөн зориулалтын ачигч, чирэгч тээврийн хэрэгслээр зөөвөрлөн ирсэн, эсвэл цагдаагийн алба хаагчийн хүргэж ирсэн тээврийн хэрэгслийг хашаанд нэвтрүүлэх;

4.4.2. тээврийн хэрэгслийг хүргэж ирсэн ажилтныг байлцуулан тээврийн хэрэгслийн гадна тал, ачаа, тээшийг үзлэгийн тэмдэглэлтэй тулгаж хүлээн авах ба энэ тухай дүрс бичлэгээр баримтжуулах;

4.4.3. тээврийн хэрэгслийн хаалга, шатахууны савны таг, тээшний хэсэг цоожгүй бол доторх эд зүйлс, нэмэлт тоноглол зэргийг шалгаж, тэмдэглэл хөтлөх;

4.4.4. тээврийн хэрэгслийн ачаа тээшинд түргэн муудаж чанараа алдах, хөлдөх хүнсний бүтээгдэхүүн, бараа материал илэрсэн тохиолдолд жолооч /эзэмшигч, өмчлөгч/-д хүлээлгэн өгөх, хэрэв жолооч /эзэмшигч, өмчлөгч/ байхгүй, эсхүл тэсэрч дэлбэрэх, мансууруулах бодис, галт зэвсэг, сум, ангийн мах, арьс зэрэг хуулиар хориглосон ачаа, бараа илэрсэн тохиолдолд аймгийн Цагдаагийн газрын ерөнхий жижүүр болон хашааны үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэж байгаа байгууллагын холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;

4.4.5. ээлж хүлээлцэхдээ тухайн хашаа /байр/-нд тээврийн хэрэгсэл бүрийг анх хүлээн авсан тэмдэглэл, бүртгэлтэй тулгаж, гарын үсэг зурж баталгаажуулах;

4.4.6. Цагдаагийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх хэсэгт заасан замын хөдөлгөөний дүрэмд түр, эсхүл удаан зогсохыг хориглосон газарт зайлшгүй зогсолт хийсэн тохиолдолд түр саатуулагдсан тэврийн хэрэгслийг цагдаагийн алба хаагчийн шийдвэргүйгээр жолооч /эзэмшигч, өмчлөгч/-д хүлээлгэн өгч, хашаанаас гаргах;

4.4.7. Энэхүү журмын 4.4.6-д зааснаас бусад тохиолдолд аймгийн цагдаагийн газрын ерөнхий жижүүр, эсхүл гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тээврийн хэрэгслийг жолооч /эзэмшигч, өмчлөгч/-д хүлээлгэн өгч, хашаанаас гаргах.

4.5. Энэхүү журмын 4.4.4-д заасан мэдээллийг хүлээн авсан албан тушаалтан хуульд заасан холбогдох арга хэмжээг авч, аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

4.6. Тээврийн хэрэгслийг техникийн оношлогоо, шинжилгээ хийлгэхээр түр саатуулах хашаа /байр/-наас авч гарах, буцааж хүлээн авахдаа энэхүү журмын 4.5-д заасныг баримтална.

Тав.Бусад

5.1. Түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагааны төлбөрийн хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тогтооно.

5.2. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үед иргэн, байгууллагад учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцна. Хохирлын асуудлыг гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.3. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсэн, түр саатуулах хашаа /байр/-нд байсан хугацааны төлбөрийг буруутай этгээдээр төлүүлнэ. Хэрэв төлбөрийг хариуцвал зохих этгээд нас барсан тохиолдолд төлбөрийн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.4. Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа /байр/-нд тээврийн хэрэгсэл, бусад эд зүйл битүүмжлэн хадгалах тохиолдолд уг хашаа /байр/ нь цагдаагийн байгууллагын өмчлөл, эзэмшилд байгаа бол төлбөрөөс чөлөөлж болох ба бусад байгууллагын эзэмшлийн түр саатуулах хашаа /байр/-нд битүүмжлэн хадгалах бол гэрээнд зааснаар зохицуулна.

5.5. Энэ журмын 3.8.1-д заасны дагуу тээврийн хэрэгслийг жолооч /эзэмшигч, өмчлөгч/-д хүлээлгэн өгсөн, эсхүл албан хаагчийн бичгээр буюу цахимаар өгсөн шийдвэргүйгээр зөөж шилжүүлсэн тохиолдолд төлбөрөөс чөлөөлнө.

5.6. Гүйцэтгэх ажил болон гэмт хэрэгтэй тэмцэх хойшлуулшгүй албан үүрэг гүйцэтгэж яваа шүүх, прокурор, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тээврийн хэрэгслийг аймгийн Цагдаагийн газрын даргын бичгээр өгсөн шийдвэрийн дагуу төлбөрөөс чөлөөлж болно.

5.7. Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-наас авч гарснаас хойш хохирол учирсан тухай гомдлыг хашаа /байр/-ны үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа байгууллага, аж ахуйн нэгж барагдуулах үүрэг хүлээхгүй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын оны .. дугаар сарын ..-ны өдрийн ээлжит бус .. дугаар хуралдааны .. тогтоолын хоёрдугаар хавсралт

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагааны төлбөрийн хэмжээ

Нэг. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Төлбөрийн хэмжээ /нэг удаа/
1.	Мотоцикл	25.000
2.	Суудлын автомашин, микроавтобус /жолоочоос гадна 8-аас илүүгүй хүний суудалтай/, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин	60.000
3.	Бүх жин нь 5000 кг хүртэл ачааны, 40 хүртэл хүний суудалтай автобус, трактор	60.000
4.	Хүнд даацын ачааны автомашин, том оврын автобус, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл	90.000

Хоёр. Түр саатуулах хашаа /байр/-ны төлбөрийн хэмжээ

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Төлбөрийн хэмжээ /нэг хоногт/
1.	Мотоцикл	4.000 төгрөг
2.	Суудлын автомашин, микро автобус /жолоочоос гадна 8-аас илүүгүй хүний суудалтай/, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин	6.000 төгрөг
3.	Бүх жин нь 5000 кг хүртэлх ачааны, 40 хүртэл хүний суудалтай автобус	10.000 төгрөг
4.	Хүнд даацын ачааны автомашин, том оврын автобус	15.000 төгрөг
5.	Тусгай зориулалтын, том оврын тээврийн хэрэгсэл	25.000 төгрөг